

ТҮҮХ-СОЁЛ СУДЛАЛ

ЦАЙНЫ ЗАМ БА МОНГОЛЧУУДЫН ЦАЙНЫ СОЁЛ

Б. Ургаацэцэг

Монгол түүхийн салбарын докторант

БНХАУ, Өвөрмонголын их сургууль

Монгол судлалын дээд сургууль

2471865706@qq.com

А. Ариунболд

Доктор /Ph.D./

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль

bayn.boldoo@gmail.com

Хураангуй: Хятад орон бол цайны эх нутаг, цайны соёл, гарал үүслийн төв юм. Харин монголчууд цайг хэрэглэж ирсэн нь бас л эртний түүхтэй. Тэр дундаа XIII зуунд Монголчууд Хятад орныг эзэлснээр цайг хэрэглэх явдал нэмэгдэв. Ялангуяа Юань улсын үед ордны доторх Монгол язгууртны давхаргынхан өмнөд орноос гаралтай цайг ууж байжээ. Монголын төр говийн ард ухран гарсны сүүлээр бурхны шашин Монгол оронд дэлгэрэхтэй зэрэгцэн монголын бүх давхаргын хүмүүс цайтай ойртож эхлэв. Гэвч Чин улсаас өмнө, Монгол нутагт ирж байсан цай хэмжээ хязгаартай байсан учраас цай уух нь зөвхөн Монголын язгууртны давхаргын хүрээнд явагдаж байжээ. Тус өгүүлэлд Монголчуудын цай хэрэглэх болсон түүхэн явцыг шинжилж, Монголчуудын ахуй амьдралд цайны үзүүлсэн нөлөө, түүхэн замналыг тодруулахыг зорив.

Түлхүүр үг: Хятад, Цай, Цайны зам, Монгол, цайны соёл

УДИРТГАЛ

Цай нь цайны ургамлын /*Camellia sinensis*/ навч, нахиа, ишийг олон янзын аргаар бэлтгэн боловсруулсан хүнсний бүтээгдэхүүн юм. Мөн цай нь энэхүү ургамлын боловсруулсан навчыг халуун болон буцалсан усанд хийж хандлан бэлтгэдэг анхилуун үнэр, аагтай ундааг хэлнэ. Дэлхийд хамгийн өргөн тархсан ундаа нь усны дараагаар цай ордог. Цагаан, шар, ногоон, хар гээд хэд хэдэн төрлийн өнгө, үнэр, амт аагтай цай байна. Цайны ургамал нь зүүн өмнөд Ази, тэр дундаа зүүн хойд Энэтхэг, хойд Бирм, баруун өмнөд Хятад, Төвөд орчмоос гаралтай ба өдгөө 52 гаруй улс оронд тархжээ. Хятадад МЭӨ II зууны

үеийн цайны хэрэглээтэй холбоотой бүртгэл байгаа нь хамгийн эртнийх болно. Дараа нь Японд 589-618 оны үед буддын шашинтай лам нараар дамжин түгсэн аж.

Цайны эх орон бол Хятад. Хятадууд цайны ид шидийг эртнээс мэдэж, цай үйлдвэрлэлийг төрийн хяналтад хатуу чанга барьж иржээ. Хятадтай хийсэн худалдаанаас бусад улс орнууд их хэмжээний алдагдал хүлээж ирсэн нь энэхүү цайтай холбоотой. Худалдааны төлбөрт их хэмжээний алт, мөнгийг Хятадад цутгаж оронд нь дэлхийн хаана ч тарьж ургуулж чадаагүй цайны бутнаас л авдаг навчийг худалдан авахад хүрдэг болохоор тэр ажээ. Цай өөрөө хар, цагаан, шар, ногоон, бор, улаан гээд олон өнгөтэй, төрөл бүрийн амтай боловч энэ нь нэг л зүйлийн бутнаас гаргаж авдаг агаад хуурах, жигнэх, исгэх зэрэг олон аргаас хамаарч олон янз байдалтай болдог ажээ.

Хятад бол эртний дорнын урт түүхтэй улс юм. Хятадын соёл иргэншил, эртний Египетийн соёл иргэншил, Грекийн соёл иргэншил, эртний Энэтхэгийн соёл иргэншил эртний Вавилоны соёл иргэншил нь хамтаар хүн төрөлхтний соёл иргэншлийн газрын зургийг бүрдүүлдэг. Өнөөгийн Бүгд найрамдах Хятад ард улс нь 9.6 сая хавтгай дөрвөлжин км газар нутагтай, 1.3 тэрбум хүн амтай, 56 үндэстэн нэгэн гэр бүл болж зэрэгцэн амьдардаг бөгөөд өргөн уудам газар нутаг, олон төрлийн газрын байрлал, цаг уур, соёл, аялал жуулчлалын бүс нутагтай юм. Хятад бол дэлхий дээр хамгийн анх цайг ургуулж, хэрэглэж ирсэн цайны эх нутаг төдийгүй олон үндэстний цайны уламжлалтай газар юм. Цай нь сүү, тос, эм, цэцэг... аль алинтай нь уусан зохицдог гайхалтай идээ ундаа ба дэлхийн олон янзын соёлыг нөхцөлдүүлж тархаасан соёлын зам болдог³³.

Цай нь дундад орон/*хятад*/ улсаас гаралтай болохоор урт удаан хугацааны түүхтэй юм. Уламжлалт ярианд “Шен нүн”-ий үед, хүмүүс хээрийн цайны модыг илрүүлж, хор тайлах эмийн оронд хэрэглэж байжээ. Жоу улсын үед хүмүүс цайны модыг хашаанд ургуулжээ. Чунь чий-ийн үед цай нэгэнт тахилгын бодис */биет юмны бүтсэн эд, эд хэрэглэл/* ба ногоогоор хэрэглэгдэж байв. Байлдаант улсын үед цайны үйлдвэрлэл, худалдаа үргэлжлэн хөгжиж, Баруун Хан улсын үед цай нь нэг зүйлийн таваар болов. Баруун Жинь улсын үед сүм хийдэд ургуулсан цайг албанд барьдаг болгожээ. Өмнөд, умард төрийн үед бурхны шашин ихээр дэлгэрч ууланд сүм хийд цогцлон босож, цай тарихгүй сүм хийд гэж байхгүй болов. Улмаар олон сүм хийдүүдээс алдартай цайнууд гарч эхлэв. Тан улсын үе болоход цайг бүх улсын хэмжээнд тариалан түгэн дэлгэрч, цай нь хүмүүсийн уух дуртай идээ ундаа болжээ. Жүньюань оронд/*хатан голын дунд, доод урсгалын сав газар орныг хэлэх бөгөөд хятад*

³³ *нэвтэрхий толь* — *Википедиагаас*

үндэстний үүссэн голомт нутаг. хятадаар 中原地区 / цай уух ёс заншил бүрэлдсэнээс мянган жилийн дараа Монголчууд ихээр цайг хэрэглэх болжээ.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Хятадаас цайны бутыг эвтэйхэн салгаж чадсан хүмүүс бол Япончууд. Тэд VIII зуунд буддизмын лам нараар дамжуулан цайны бутыг олж аван тарималжуулсан юм. Эхэндээ Япончууд нь Монголчууд эдүгээ хүртэл өргөн дэлгэр хэрэглэдэг шиг хэвд оруулан шахсан туо-ча-г хэрэглэдэг байв. Харин XII зуунд Японд зэн буддизм дэлгэрснээр ногоон цайг өргөн дэлгэр уух болжээ. Өрнө дахин цайны амтанд орж, дэлхийн хүчирхэг гүрэн болсон Англичууд цайг өргөн дэлгэр хэрэглэх болсон үед хилээ хаачихсан ба гадаад худалдаа эрхэлдэггүй байсан тул Японоос цайны бут гадагш гарсангүй.

Харин Хятадууд цай ургадаг нутагт гадаад иргэнийг оруулдаггүй, цай үйлдвэрлэх технологийг байнга нуусаар ирсэн учир Англичууд хар, ногоон цай үнэндээ нэг л зүйлийн *Camellia sinensis* хэмээх бутны навч гэдгийг 1840-өөд он гарч байж мэдсэн гэдэг. Роберт Форчүүн хэмээх ботаникийн мэргэжилтэн 1844 онд Хятадын цай тариалдаг хориотой нутагт нууцаар нэвтрэн орсон тухай сонирхолтой түүхийг Laura C. Martin "Tea-The Drink That Changed the World", Tuttle Publishing, 2007 хэмээх номоос харж болно. Роберт хятад хэлийг богино хугацаанд төгс сурч, манж маягаар гээг тавин хятад хүн болон зүс хувилгаад цайны нутагт нэвтрэн орж, ботаникийн нарийн судалгаа хийсэн төдийгүй 1848, 1853 онуудад дахин очиж, цайны үрийг хулгайгаар авч, 20 мянган бутыг Английн колони Энэтхэгт илгээснээр алдарт Даржээлин цай үүсчээ. 1880-аад он гэхэд Энэтхэгийн Ассам нутаг дахь цайны үйлдвэрлэл Хятадыг хэдийн давж, зах зээлээ олсон байв.

Хятадын Пү-ар буюу бор цай богшоод ирэхээрээ хар өнгөтэй болдог. Үүнийг бас туйвантай цай гэж ч нэрлэх нь бий. Хийдэг технологи нь их өвөрмөц, олон жилийн настай цайны бутнаас навчийг түүн тусгай бактериар исгэсний дараа хуурч болгодог. Алс замд зөөх зорилгоор хэв оруулан нягтруулан шахсаныг нь Монголчууд Төвдөөр дамжуулан хунз хунзаар нь тэмээн жингээр оруулж ирдэг байжээ. Бор цайнаас гадна бидний өвөг дээдэс Туо-ча буюу хар, ногоон цайг нийлүүлэн хуурч, цайны шинэ навч хийн исгэж, хэвэнд шахсан цайг өргөн дэлгэр хэрэглэдэг байжээ. Уг цайг Монголчууд Хятадаас зөөж, Орост хүртэл экспортолдог болсноор цайны зам хэмээн нэрлэгдсэн Азийн эх газрын худалдааны нэг томоохон маршрут үүссэн түүхтэй. Оросын хаанд цайг анх хүргүүлж, амтыг нь мэдүүлсэн хүн бол Хотгойдын Алтан хаан Омбо-Эрдэнэ болохыг түүх өгүүлдэг.

XIX зууны сүүл үед Шотландын наймаачин Жэймс Марр гэдэг хүн Гүржид анх цайны бут оруулж тарималжуулсныг социализмын үеэс ууж

дассан гүрж ногоон цайгаараа дамжуулан мэдэх болсон билээ. Гүрж цай хэдийгээр ногоон цай гэх тодотголтой ч өнөөгийн Япон, Солонгос, Хятадын уудаг ногоон цайнаас тэс ондоо агаад дээр дурдсан туо-ча-тай адил зүйл.

Монголчууд эрт дээр үеэс уулнаас цэцэг буюу модны навчийг түүн цай болгон ууж байсан мөртөө цайны төрөл зүйл олонг хэрэглэдэг байв. “Юань улсын хувцас, идээ, сууцны тухай” хэсэгт өгүүлснээр бол “Умард орны Монголчууд “На ши” гэдэг Монгол цай уух дуртай байв. Хэрмийн гаднах Монголчууд мөн цана/*нэгэн зүйл цэцэг*/ цайнд дуртай. Энэ зүйлийн цай нь Жяннань газрын цайтай адилгүй, шууд цанын зөөлөн навчийг түүн авч хатаасны дараа усанд дэвтээдэг”³⁴. Үүнээс гадна “Монголын зан аалийн ойлбор”-т “Эрт цагт Монголд гарсан сөдөн цай, шид/*нэг зүйлийн ургамал*/-ийн цай зэргийг жил бүрийн долоон сард түүж авах цаг, навчны цай болбоос алимны навч, шидийн навч эдгээрийг цай болгож хэрэглэмой. Ургамлын үндсээр хийх цай болбоос сөдийн үндсийг цай болгож хэрэглэн өөр зүйлийн цай болбоос цөм гадаад газраас ирмой”³⁵ гэж тэмдэглэжээ. Жүнюань орны цайны хөгжлийг дагалдан Монголчууд нутгийн цайгаа ууж байснаар барахгүй өмнөд орны цайг ч бас ууж байв. Үүний тухай тодорхой тэмдэглэл Юань улсын үеэс тэмдэглэгдэн үлджээ.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

XIII зуунд Монголчууд Жүнюань орныг ноёрхохтой зэрэгцэн дээд давхаргынхан өмнөд орноос гаралтай цайг ууж эхэлсэн байна. Хааны хүнсийг хариуцдаг эмч Хүсэхүй, Хубилай сэцэн хаан (1215-1294 он)-аас Заяат хаан (1304-1332 он) хүртэлх Монгол хаадын өдөр тутмын хүнсийг данслан тэмдэглэж, 1330 онд “Идээ ундааны жинхэнэ товч”-ийг бичиж дуусгажээ. Тус номд цайг арван таван төрөл зүйлд хувааж, зооглох аргыг тусад нь танилцуулжээ³⁶. “Юань улсын цай арилжаалах дүрэм” хэмээх Сүй юэй-ийн өгүүлэлд, Монгол язгууртнуудын цай ууж байсан байдлыг тусгасан боловч Монголчуудын ууж байсан цайны тухай ер дурдсангүй. Үүнээс гадна Юань улсын үеийн жуулчдын тэмдэглэлд, жирийн Монголчуудын цай ууж байсан тухай мэдээ харагдсангүй. Үүнээс мэдэгдэх нь, Юань улсын үед Их нийслэл /*одоогийн Бээжин*/ ба Дээд нийслэл Шанду /*одоогийн Өвөр Монголын Шулуун хөх хошуунд буй шанд хот*/ дэх төрийн түшмэдийн золоор /*ачаар*/ өмнөд орноос алба болгон барьсан цайг амталж байжээ. Юань улсын Монголчуудын

³⁴ 韩志远：《元代衣食住行》，中华书局·2016年1月，第170页。

³⁵ [Чин] Лувсанчойдон：Монголын зан аалийн ойлбор. ӨМАХХ., 1979. т 35

³⁶ [元] 忽思慧著，张秉伦·方晓阳译注：《饮膳正要译注》·上海古籍出版社·2014年11月，137-143页。

хувьд цай бол нэг зүйлийн бүрэлгэх бодис, харин амьдралд заавал шаардагдах зүйл биш болно.

Юань улсын ноёрхлын хугацаанд цай нь Монголчуудын хувьд нэг зүйлийн эрх сүрийн бэлгэдэл, гэвч өдөр тутмын идээ ундаа биш байв. Учир нь Мин улсын үеийн Хятад, Монголын хоорондох арилжааны таваараас үзвэл Монголчууд жүньюань орноос ухран гарсны дараа амьдралдаа цайг тийм ч ихээр шаардаж байсангүй. Юнлө-ийн/*хаан*/ анх (1402) оны арван нэгэн сард Урианхайн ахлагч Харгудай түүний харьяат Төгс зэрэг 230 хүн ирүүлж, морь өргөв. Зарлигаар ёслолын журганаас морины өртгийн хариунд зоос, өмсгөл хувцас соёрхож, сайн морь бүр 50 сүхэс/*сүх шиг*, юань улсын үеийн зоосны нэгж/, дунд зэргийн морь бүр 40 сүхэс, тааруухан морь бүр 30 сүхэс, бас морь бүрт нь өнгөт бүхэл торго нэг хэсэг өгчээ³⁷. Тус удаагийн таваарын солилцоонд цай байсангүй. Үүнээс хойш бараг 170 гаруй жилийн хугацаанд Мин улсын ноёрхлын эхэн үед Монголчууд цайг тулган шаарддаггүй байжээ. Учир нь Монголчуудад хүртээж байсан зүйлсэд цай ер байсангүй. Юнлө (1402-1424 он)-ээс Сүэн дө (1425-1435 он)-ийн хооронд ойрадын Шүнь нин ванд арван хэсэг дотор гадар бүхий өнгөт торго, түүний хатанд таван бүхэл ... Жэн түн-ий хоёрдугаар (1436) онд Татарын Монгол ванд арван таван бүхэл дотор гадар бүхий өнгөт торго ... Тянь шүнь (1457-1464 он)-ээс сүүлээр томилогдон ирсэн гол дэд элч бүрт нэг өвч нэхмэл хоргой хувцас, нэг зүйрэй/*хос*/ оймс гутал шагнав. Гуйсан нь: Монгол ван хийгээд түүний ойр төрлийг багтаасан нэг, хоёр, гуравдугаар дэсийн түрүүчүүдэд/*ахлагчид*/ хишиг хүртээх явдал болой. Хун ди-ийн/*хаан*/ гуравдугаар (1489) онд гуравдугаар дэсээс доош хүмүүст хишиг хүртээхгүй болвой³⁸.

Мин улсын ноёрхлын дунд үед Монголчууд мөн урьдын адил цайг хэрэгсэж байсангүй. Тухайн үед Монголчууд ба Мин улс хоорондын солилцооны таваарт цайг бас л байсангүй. Хун ди (1487-1505 он)-ийн үед... Монголчууд хаалганы доторх ард лугаа харилцан арилжаа хийжүхүй. Бид торгон утас, шоо бүс, хөвөн, зүү утас, дээс, нэхмэл бараа, сам шүүр, амуу будаа, давс, чихэр, артай бүс, халиуны арьс зэргээр Монголчуудын морь, үхэр, хонь, илжиг, луус, арьсан дах зэргийг сольж байвай³⁹. Тус тэмдэглэлд,

³⁷ 《明太宗实录》· 卷二五 永乐元年十一月乙亥，台北，台湾，中央研究院历史语言研究所校印· 0450 页。

³⁸ 薄音湖，王雄：《明代蒙古汉籍史料汇编》（第二辑）《明会典》（节录）· 卷一· 《给赐》第215页。

³⁹ 薄音湖：《明代蒙古汉籍史料汇编》（第四辑）卷之八· 《中三边二》· 内蒙古大学出版社· 2006年10月，第92页。

Монголчууд болоод хэрмийн доторх ардын хоорондох солилцооны бодисыг нэлээд нарийн заасан байна. Гэтэл тэдгээрийн дотор цай байгаагүй байна.

XVI зууны дунд үед Монголчууд Мин улсаас өдөр тутмын хэрэглээний зүйлсээс гадна бурхны шашны хэрэгслийг гуйх болсон байна. Жянь жин-ий гуравдугаар (1551) онд Монголчууд морь өргөн барьсны хариуд алтан оройтой том малгай, өнгөт торгон хувцас шагнав ... гуйсан нь: Лүн чин-ий зургадугаар (1572) онд Шүн и ван төвөд судар, алтаар бичсэн судар таван боть, бэхээр бичсэн судар таван боть, хоёр төвөд ламыг түүний оронд очуулж ном уншуулахыг айлтган гуйв. Шүн тянь фу урьдаар томилон явуулсан төвөд лам бүрт идэш, хувцас, арван лан мөнгө олгов. Буцаж ирэхэд орхимж, исрэй/*лам нарын суух олбог*/, олсоор нэхсэн ламын дээл, гутал оймс тус бүр нэг хос хүртээн хайрлав⁴⁰.

Монголчууд жүнюань орноос ухран гарсны дараа ойролцоогоор хоёр зуун жилийн дотор Мин улсаас хэрэгсэж байсан бодис нь голдуу амуу хүнс, бүс бараа болно. Жянь жин-ий гучин гуравдугаар (1554) онд... гурван сараас таван сар хүртэлх хугацаанд Сүэнь фу, Да тун хоёр балгасанд адууны зах байгуулж дуусгалаа, Монголчууд мөн л хонь үхрээр будаа хүнс солихоор гуйв⁴¹.

Лүн чин-ий тавдугаар (1571) онд Монголчууд морь, бусад тэжээвэр, арьс ноосоор мин улсын алт, мөнгө, өнгөт торго зэрэг олон таваарыг сольж албаны зах хаав⁴².

Мин улс хийгээд Монголчуудын хоорондох 170 гаруй жилийн харилцааны тухай дээрх түүхэн тэмдэглэлүүдийг ажиглавал, 1402-1572 онд тэдний солилцооны бодис дотор цайг ер дурдагдсангүй. Үүнээс илт ажиглагдах нь Мин улсын дунд үе хүртэл Монголчуудын амьдралд цай ихээр шаардлагагүй байжээ.

XVI зууны сүүл үед Монголчууд бурхны шашин шүтэх үеэс цай хэрэгсэх болжээ. Төвөдөөс уламжлагдсан бурхны шашны нөлөөгөөр Монгол оронд цай нэлээд чухал зүйл болсон байна. Учир нь лам нарын бясалгал нь цайнаас холдошгүй юм. Өмнөд орны цай нь Монголчуудын ууж байсан цана,

⁴⁰ 薄音湖, 王雄: 《明代蒙古汉籍史料汇编》(第二辑)《明会典》《(节录)·卷一·《给赐》》内蒙古大学出版社·2006年10月, 第217页。

⁴¹ 薄音湖, 王雄: 《明代蒙古汉籍史料汇编》(第二辑)《三云筹俎考》《(节选)·内蒙古大学出版社·2006年10月, 第400页。

⁴² 薄音湖, 王雄: 《明代蒙古汉籍史料汇编》(第二辑)《四夷考》《(节选)·内蒙古大学出版社·2006年10月, 第524页。

сөдөт, шид болоод алимны навчин цайтай адилгүй, жинхэнэ сайн цайг уух нь хүмүүсийн нойрыг сэргээж, унтахыг багасгадаг⁴³ байна.

Фэн янь-ий “Фэн овогтны үзэж сонссон тэмдэглэл”-д “Сүэнь зүн кө юань (713-741)-ий үед, Тайшань уулын Лин янь сэ хийдэд нэгэн шулмасыг дарагч их багш бясалгалын ухааныг ухуулав. Бясалгалд суухад огтхон ч унтаж болохгүй, мөн шөнийн хоол ч идэж болохгүй зөвхөн цай ууж болдог. Хүмүүс биедээ цай авч, түүнийгээ чанаж ундаа болгомой. Үүнээс хожим хүмүүс харилцан дуурайж аажмаар цай уух дадал бүрэлдэв”⁴⁴ гэж тэмдэглэсэн байв. Монголчууд бурхны шашин шүтэхийг дагалдан Монгол газар сүм хийд олшрон, лам нарын тоо улам нэмэгдэж Монгол орон дахь цайны хэрэгцээг ихэсгэжээ. Төвөдөөс уламжлагдсан бурхны шашныг дагалдан ирсэн цай аажмаар Монголчуудын улс төр, шашин шүтлэг болоод өдөр тутмын амьдралд гүнзгий нэвтэрсэн байна.

Түүхэн тэмдэглэлийг үндэслэвэл: “Лүн чин-ий зургадугаар (1572) онд Сэцэн (1540-1586) ... Хэ си-ийн илбэн тохинуулагч сайд Ляо фэн жиэ-д бичиг илгээн, бурхны тахил цай олох санаатай хэмээв”⁴⁵. Үүнээс дөрвөн жилийн дараа Лүн чин-ий зургадугаар (1572) онд Алтан хаан бурхан тахихын тулд Гансу-ийн Жюнь мэн-ээс цайны зах нээхээр гуйчлав. Түүхэн баримт доорх мэт:

“Шанси-ийн Сүй ши түшмэл Ли ши чэн хэлсэн нь < Төвөдийн цайгаар амин тэжээл болгож байдаг. Хэрэв Монголчууд үүнийг ашиглаж төвөдийг засахад хүрвэл Төвөд лавтайяа Монголыг дагамай. Хойшдын хор маш их >. Цэргийн журган: < цайны захыг яахан хялбар нээж болох ажгуу? гэвч Монгол ван нэгэнт бурхан залав, сүм нэмж байгуулахад заавал цай зарах хэрэгтэй хэмээмой, түлхэхийн аргагүй болой. Байдлыг ажиж, хэрэв Монголын ван цайгаар морь солихоор гуйваас, албаны цай арвин байхгүй. Уг нь Төвөд лүгээ цайгаар морь сольж байвай. Тэнгэрлэг төр хууль тогтоолтой, хэн аймшиггүй арилжих буй, зуу арваадаар хэмжээлэн өгч, төрийн үлэмж хишгийг үзүүлье ээ > эзэн зөвшөөрөв”⁴⁶. Саган Сэцэн хийгээд Алтан хаан хэдэн удаа бурхан залахын учир Мин улсаас цай гуйсан баримтыг энд бүгдийг жагсаахгүй. Үүний тухай Захчид Сэцэн абугай дурдсан нь: “Монгол ноёрхогчдоос алтан үсэгт

⁴³ [西晋] 张华著·唐子恒点校:《博物志》·《食忌》·凤凰出版社·2017年10月。第50页。

⁴⁴ 封演:《封氏见闻记》·第六卷·《饮茶》·第71页。

⁴⁵ 薄音湖:《明代蒙古汉籍史料汇编》·第四辑·卷之十四·《西三边》·内蒙古大学出版社·2007年4月。第371页。

⁴⁶ 《明神宗实录》·卷六七 永乐元年 九月己未, 台北, 台湾, 中央研究院历史语言研究所校印·1459页。

ном, лам, цайны зах нээхийг шаардсан явдал нь түүхэнд гараагүй явдал болно”⁴⁷ гэжээ. Гүйцэд хэмжээний цай байвал сая үй олон лам нарт өглөг өргөж, Монгол газарт бурхны шашныг уламжлан, ноёрхлоо бэхжүүлж чадах учраас Монголчуудад шинэ шашны хөдөлгөөн – Төвөд орж манз/*хурал хурж буй лам нарын уух цай, цайны хүндэтгэл*/ чанах үйл гарч иржээ. Үүний тухай Лүй вэнь ли дурдсан нь: “Алтан хаан Төвөдийн бурхны шашныг Монголд оруулсан нь Монголчууд бурхны гурван эрдэнийг шүтэх ба манз чанах өглөгийн үйлийн эхлэл болно. Энэ нь Монголын бүх аймгийн аж ахуй, зан заншилд маш их нөлөө үзүүлжээ”⁴⁸ хэмээв.

Умард юань улсын үед Монголчууд бурхан тахихаас гадна, бэлэврэлд цайг хэрэглэж эхэлжээ. Түүхэн баримтыг үндэслэвэл: “цагагчин могой (1580) жилийн хавар, хоёр сард, вангийн хатан нас барсан учрыг вангийн элч мэдүүлвэй, хэлсэн нь: < бэлэврэх этгээд нэр хүндтэй >, элч зарж, цагаан боолт дөрөв, цагаан торго дөрөв, цагаан бүс арван хоёр, цай, жимс чихэр зэргээр тахилын эд болгоё” гэх 1580 оны тэмдэглэлд буй. Гэвч XVI зууны сүүл үед Монгол оронд цай нэлээд ховор чухал /*маш ховор, олоомшгүй цөөн*/ байжээ. Жүнгин хатан (1550-1612)-ы цай худалдан авсан түүхэн тэмдэглэлд: “цагагчин могой (1580) жилийн хаврын хоёр сард, Сан нианзи/*三娘子*/ Сүэнь фу-ийн мэдэгч түшмэлд хорин лан мөнгө өгч цай захив”⁴⁹. Үүнээс гадна (вань ли-ийн арван есдүгээр оны долоон сард), Жүн шүнх хатан Сан нианзи Жэн (Жэн лүэ 1530-1600) их ноёдод толгой мэхийн ёслол бараадаж баймой ... баруун газар хүрснээс нааш, буруу явдал хийсэндээ ихээр гутарч, чухал бүхий зүйлийг хүсэх зориг байхгүй болвай. Эдүгээ арван лан мөнгө бэлтгэж, их ноён увдис хүчээр артай бүс арав, цай найман лонх, цагаан торгон гарын алчуур тавин хэсэг, шунх/*чулуулгаас гарах улаан өнгөтэй будаг*/ хоёр лан, шау хөхүүр дөрвөн лан, жижиг тогоо арав, сэрүүцэх дэвүүр арав, үсэг бичих цаас зуун хуудас олж өгмүү. Хэрэв эдгээр зүйлсийг бүрдүүлж өгвөл, би таны ачийг насан турш мартахгүй. Дахиад хичээнгүйлэн бараадъя. Бас зургаан лан мөнгөөр бүс арван бүхэл авч, үлдсэнээр нь цай авъя”⁵⁰ гэсэн тэмдэглэл байна. Дээрх түүхэн баримтыг ажиглавал, 1580 онд Сан нианзи 20 лан мөнгөөр Мин улсын

⁴⁷ 札奇斯钦：《北亚游牧民族与中原农业民族间的和平战争与贸易之关系》，台湾，台北，正中书局·第507页。

⁴⁸ 吕文利：《俺答汗建立“政教二道”中心的文本分析以及熬茶布施的开端》，西部蒙古论坛·2017年第1期

⁴⁹ 薄音湖，王雄：《明代蒙古汉籍史料汇编》（第二辑）·《扶夷纪略》·内蒙古大学出版社·2006年10月。第169页。

⁵⁰ 薄音湖，王雄：《明代蒙古汉籍史料汇编》（第二辑）·《与经略尚书郑洛书》·内蒙古大学出版社·2006年10月。第175页

түшмэлээр цай авахуулжээ. 11 жилийн дараа тэрээр бас цэргийн явдлын бүгдийг захирагч сайд Жэн лүэ-ээр 6 лан мөнгөөр цай болон бүс захисан явдал нь тухайн үед Монгол газарт өмнөд орны цай маш ховор байж, язгууртнууд ч түүнийг тийм амар олж авч чадахгүй байжээ.

XVII зуунд Монголчууд цайг бурхны тахил ба бэлэвсрэлд хэрэглэж байснаас гадна зочин дайлахад идээний дээжээр барьж байв. Мин улсын Сяо да хөн (1532-1612 он) “Монгол зан суртахууны тэмдэглэл”-д “Монголчууд зочин дайлахад юуны өмнө сүү, цай, шар тосоор дайлаад дараагаар нь архи махны зүйлийг гаргаж ирнэ”⁵¹ хэмээн бичсэн байна. Тус ном нь баруун гарын Монголчууд, даруй Ордос, Түмэд, Харчин түмний нийгмийн зан заншлыг тусгажээ. Тухайн үед эдгээр газрын Монголчууд цайг зочин угтах идээний эрхэм болгож байсан нь мэдэгдэж байгаагаас гадна цай нь Монголчуудын өдөр тутмын идээний зүйл болж чадаагүй байжээ.

Чин улсын ноёрхлоос өмнө, Монгол газарт уламжлагдан ирсэн цай олон биш боловч тэр нь Төвөдөөс уламжлалтай бурхны шашны Монгол оронд дэлгэрэхийг дагалдан өмнөд орны цай Монголчуудын тахилгын зүйл ба зочин дайлахад хэрэглэх идээний дээж болсон байна. Улмаар Чингийн захиргааны үед Монгол газар хятад худалдааг дэмжин хөгжүүлэх болсноор цайны худалдаа өргөжин тэлжээ. Чин улс болоод Хаант Орос улсын хооронд 1689 оны 8-р сарын 28-нд Нэрчүү голын эрэг дэх Нэрчинск гацаанд Оросын Романов хааны болон Хятадын Чин улсын төлөөлөгчид нэгэн гэрээ байгуулсан нь энэ хоёр орны түүхэн дэх анхны гэрээ байсан бөгөөд хожим нь Нэрчүүгийн гэрээ гэж нэрлэгдсэн. Уг гэрээгээр хоёр улсын хилийг тогтоож, харилцан худалдаа хийхээр тохирсон ч зам харилцаа байхгүй, зарим зүйл нь тодорхойгүй байснаас болж уг гэрээний худалдаатай холбоотой заалт хэрэгжихгүй байсаар 1727 оны 8-р сарын 20-нд Буурын гэрээгээр хоёр улсын хилийг тодотгож, мөн оны 10-р сарын 21-нд байгуулагдсан Хиагтын гэрээгээр хоёр орны хооронд худалдаа хийх үндсэн зарчмуудыг тодорхойлсноор худалдаа хийх таатай нөхцлийг бүрдүүлжээ. Эдгээр гэрээний үндсэн дээр Оросууд Хиагтад, Хятадууд хилийн нөгөө талд нь Маймаачин нэртэй худалдааны боомт байгуулж хоёр орны худалдаа эдгээр боомтоор бараг 300 орчим жил явагдсан юм. 1869 онд Суэцийн суваг нээгдэж, 1903 онд Транссибирийн төмөр зам ашиглалтад орсноор ач холбогдол нь нэлээд буурч улмаар 1911 оны Синхайн хувьсгал, Дэлхийн I дайн, Октябрийн болоод Ардын хувьсгалын улмаас үлэмж багассан хэдий ч 1927 он хүртэл тодорхой хэмжээгээр үргэлжилж байсан түүхтэй.

⁵¹ [明] 萧大亨：《史料四编 北虏风俗》·台北广文书局·1972年，第10页。

Хиагт-Маймаачингийн боомтоор Хятадын талаас зөөдөг гол ачаа нь цай байсан учраас уг боомтыг дайран өнгөрөх замыг “Цайны зам” гэж нэрлэх болжээ. Бараг 9000 км үргэлжлэх Цайны замын эцсийн цэг нь Оросын Москва хот байсан юм. Хятадын нутагт ургуулж хураасан цайг Хаалган хүргэж тэндээс Замын-Үүд, Чойр, Хүрээгээр дайруулан Хиагтад хүргэдэг байжээ. Цайг малын нойтон арьсанд боож тэмээн жингээр зөөнө. Нэг удаагийн жингийн цуваанд хэдэн арваас хэдэн зуун тэмээ явах ба нэг тэмээ нуруундаа 200 кг, тэргэнд хөллөсөн үед 400 кг ачаа тээвэрлэдэг байв. Тэмээн жин хоногт 30-40 км замыг туулдаг байжээ. Байгаль, цаг уурын онцлогоос болж тэмээн жингийн тээврийг намар, өвлийн улиралд хийж, Хаалганаас Хиагт хүртэл говь хээр, уул тал бүхий урт замыг 30-40 хоногт туулдаг байлаа. Цайнаас гадна торго, шаазан эдлэл бас зөөдөг байв. Тэмээн жин Хиагтаас буцахдаа голдуу ангын арьс, ноосон даавуу (заримдаа бүр Англи, Германд үйлдвэрлэсэн), хөвөн даавуу зэрэг бараа зөөдөг байжээ.

ДҮГНЭЛТ

Монголчуудын цайны соёл, түүнийг хэрэглэж ирсэн нь нэн эртний түүхтэй ажээ. Цайг эх нутаг Хятад газраас нь авахын зэрэгцээ өөрийн Монгол нутагтаа ургадаг цайны олон төрлийн ургамалыг түүн хэрэглэж ирсэн байна. Их Монгол улсын хаадын урагш хийсэн аян дайны үр дүнд дотор газрын цайг өргөн дэлгэр ууж хэрэглэх болжээ. Тухайлбал XIII зууны үеийн ордны доторх Монгол язгууртны давхаргынхан өмнөд оронд гардаг цайг уудаг соёл тогтоод байлаа.

Харин дараа нь XVI зууны сүүл үед Монголчууд бурхны шашныг ихээр шүтэх болсон үеэс цайг ард нийтээрээ илүү уух болсон байна. Энэ нь Төвөдөөс уламжлагдан ирсэн бурхны шашны нөлөөгөөр Монгол оронд цай нэлээд чухал зүйл болжээ. Төвөдөөс уламжлагдсан бурхны шашныг дагалдан ирсэн цай аажмаар Монголчуудын улс төр, шашин шүтлэг болоод өдөр тутмын амьдралд гүн нөлөө үзүүлсэн тусгай соёл болсон байна. Тэр дундаа XVII зуунд монголчууд цайг бурхны тахил ба бэлэвсрэлд хэрэглэж байснаас гадна зочин дайлахад идээний дээжээр барьж байв. Чин улсын ноёрхол тогтохоос өмнө, Монгол газарт уламжлагдан ирсэн цай нь Төвөдөөс уламжлалтай бурхны шашин дэлгэрэхийг дагалдан Монгол газар улам өргөн хэрэглэдэг болжээ.

Үүнээс хойш 300 жил тэмээн жин цуварсаар... түүгээр худалдааны аялал хөгжиж цайны зам нэртэй болжээ. Хятадын цай нь энэхүү замаар тасралтгүй Европ Азийн улсруу тээвэрлэгдэж байв. Вү И Шань уулнаас эхэлж Хятадын нутгийг туулж Монголын нутгаар дамжин гарсан цайны зам нь Санкт-Петербург болон Европын зарим улс хүртэл аялдаг байв.

НОМ ЗҮЙ:

- [1] Нэвтэрхий толь — Википедиагаас
- [2] Лувсанчойдон: Монголын зан аалийн ойлбор. ӨМАХХ., 1979
- [3] 韩志远: 《元代衣食住行》, 中华书局, 2016 年
- [4] 忽思慧著, 张秉伦, 方晓阳译注: 《饮膳正要 译注》, 上海古籍出版社, 2014 年
- [5] 明太宗实录, 卷二五 永乐元年 十一月乙亥, 台北, 台湾, 中央研究历史语言研究所校印
- [6] 薄音湖, 王雄: 《明代蒙古汉籍史料汇编》(第二辑)《明会典》(节录) 张华著, 唐子恒点校: 《博物志》, 《食忌》, 凤凰出版社, 2017 年
- [7] 封演: 《封氏见闻记》, 第六卷, 《饮茶》
- [8] 明神宗实录, 卷六七 永乐元年 九月己未, 台北, 台湾, 中央研究历史语言研究所校印
- [9] 札奇斯钦: 《北亚游牧民族与中原农业民族间的和平战争与贸易之关系》, 台湾, 台北, 正中书局
- [10] 吕文利: 《俺答汗建立“政教二道”中心的文本分析以及熬茶布施的开端》, 西部蒙古论坛, 2017 年
- [11] 萧大亨: 《史料四编 北虏风俗》, 台北广文书局, 1972 年